

“ҮНЭТ ЦААСНЫ ТӨВЛӨРСӨН ХАДГАЛАМЖИЙН ТӨВ” ХХК-ИЙН ИНТЕРНЭТ ДАНСНЫ ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү журам “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК /цаашид компани гэх/ нь иргэн, хуулийн этгээд (цаашид “харилцагч” гэх)-д тэдний төвлөрсөн хадгаламж дахь дансны мэдээллийг интернэтээр дамжуулан хүргэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахад оршино.

1.2 Энэхүү журам нь Монгол Улсын Иргэний хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хувь хүний нууцын тухай хууль болон компанийн дотоод мөрдөж буй холбогдох журмыг удирдлага болгоно.

Хоёр. Журмын нэр томъёо

2.1 Энэ журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

2.2 “ҮЦТХТ ХХК-ийн интернэт үйлчилгээ” /цаашид “Интернэт үйлчилгээ” гэх/ гэж төвлөрсөн хадгаламж дахь харилцагчийн дансны мэдээллийг интернэт ашиглан цахим хэлбэрээр хүргэх үйлчилгээг;

2.3 “Интернэт үйлчилгээний харилцагч” /цаашид “харилцагч” гэх/ гэж төвлөрсөн хадгаламжид данстай, интернэт үйлчилгээ авах эрх авсан иргэн, хуулийн этгээдийг;

2.4 “Интернэт үйлчилгээ үзүүлэх гэрээ” гэж энэ журмын дагуу тогтоосон нөхцөл шаардлагыг хүлээн зөвшөөрч уг үйлчилгээг авахаар харилцан тохиролцож байгуулсан гэрээг;

2.5 “Цахим үйлчилгээ хариуцсан лавлагаа, мэдээллийн ажилтан” /цаашид мэдээллийн ажилтан гэх/ гэж харилцагчид цахим үйлчилгээний талаар үндсэн ойлголт өгч, мэдээлэл, заавраар хангах, харилцагчийг үйлчилгээнд бүртгэх, эрхийг нь түр цуцлах, сэргээх эрх бүхий ХӨЭБКА-ны ажилтан;

2.6 “Интернэт дансны аюулгүй байдал хариуцсан ажилтан” /цаашид “аюулгүй байдал хариуцсан ажилтан” гэх/ гэж байгалийн болон технологийн хүчин зүйлээс шалтгаалж интернэт дансны үйл ажиллагаа тасарч, зогсох зэрэг тохиолдолд шалтгааныг тогтоох, үйл ажиллагааг сэргээх, төлөвлөгөө гаргах, түүнийг гүйцэтгэх, журамд заасан бусад үүргийг хүлээж, дотоод сүлжээ төхөөрөмжийн тохиргоог хийж хянах цахим програмын хэрэглэгчийн эрхийг зохицуулах, вирусны эсрэг програм хангамжаар хангах зэргээр гадны халдлагаас компьютерийн нэгдсэн сүлжээнд болон цахим програмд нэвтрэх, вирус тархах зэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох программистийг;

2.7 “Интернэт үйлчилгээний аюулгүй байдлын комисс” /цаашид “комисс” гэх/ интернэт дансны хэвийн үйл ажиллагаанд гарч болох эрсдлүүд, сэжигтэй үйлдлүүдэд хяналт тавих, эрсдэлтэй үйлдлүүдийг таслан зогсоох, эрсдэл гарсан бол хохирлыг барагдуулах зорилго бүхий компанийн удирдлагаас томилогдсон эрх бүхий байнгын комиссыг;

2.8 “Нууцлалын тэмдэгтүүд” гэж интернэт үйлчилгээний харилцагчийн ашиглах дараах нууц дугаар, түлхүүр үгийг хэлнэ. Үүнд:

2.8.1 “Харилцагчийн нууц дугаар” гэж программаас өгч байгаа үсэг болон тоогоор тэмдэглэгдсэн интернэт үйлчилгээнд нэвтрэх нэр;

2.8.2 “Нэвтрэх түлхүүр үг” гэж харилцагч интернэт үйлчилгээнд холбогдоход ашиглах тэмдэгт бүхий олон удаа хэрэглэгдэх нууц код;

2.8.3 “Электрон код” гэж харилцагч өөрийн данснаас шилжүүлгийн гүйлгээ хийх бүрт хэрэглэх нууц код;

2.8.4 “Цахим нууцлалын төхөөрөмж” гэж интернэт үйлчилгээний харилцагчид нэг удаагийн нууц дугаар өгч байх нууцлалын төхөөрөмж.

Гурав. Интернет үйлчилгээний эрх нээж, үйлчилгээг идэвхжүүлэх

3.1 Интернет дансны үйлчилгээний эрх авах харилцагч нь үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид данстай, интернет үйлчилгээний гэрээний нөхцөлийг хүлээн зөвшөөрч хүсэлт

гаргасан байна. Хэрэв интернет дансны үйлчилгээний эрх авах харилцагч нь ААН бол нэмж албан тоот ирүүлнэ.

3.2 Мэдээллийн ажилтан нь “Интернет үйлчилгээгээр үйлчлүүлэх харилцагчийн хүсэлт” /маягт-1/-ийг хүлээн авч мэдээллийн баазтай тулгаж шалгасны үндсэн дээр “Интернэт үйлчилгээ үзүүлэх гэрээ” /гэрээ-1/-г 2 хувь байгуулна. Үйлчилгээний эрх нээх хүсэлт болон интернэт үйлчилгээ үзүүлэх гэрээг ХӨЭБКА-ны захирал гарын үсэг зурж, тамгаар баталгаажуулна.

3.3 Интернэт үйлчилгээ нээлгэх хүсэлтийг харилцагч бүрэн бус алдаатай бөглөсөн тохиолдолд мэдээллийн ажилтан “Интернэт үйлчилгээ үзүүлэх гэрээ”-г байгуулахаас татгалзана.

3.4 Мэдээллийн ажилтан нь бүрэн гүйцэд бөглөсөн интернэт үйлчилгээний хүсэлт болон гэрээг хүлээн авч, албаны захиралд танилцуулан интернэт гүйлгээний эрхийг идэвхжүүлнэ.

3.5 Мэдээллийн ажилтан нь харилцагчийн дугаар, нууц кодыг эрх нээлгэх хүсэлтэнд заасан эрх бүхий этгээдэд биечлэн хүлээлгэн өгнө. Хэрэв эрх нээлгэх хүсэлтэнд заасан эрх бүхий этгээд өөрийн биеэр ирээгүй тохиолдолд Монгол улсын иргэний хуулийн 64.2-г заасан шаардлагыг хангасан итгэмжлэлийг үндэслэн итгэмжлэгдсэн төлөөлөгчид өгнө.

Дөрөв. Интернэтээр үзүүлэх үйлчилгээний төрөл

4.1 Компаниас дараах төрлийн үйлчилгээг интернэтээр дамжуулан харилцагчдад хүргэнэ. Үүнд:

- Төвлөрсөн хадгаламж дахь дансны үлдэгдэл, хуулга харах хэвлэх;
- Төвлөрсөн хадгаламж дахь дансанд шинжилгээ хийх;
- Үнэт цаасны арилжааны ханш харах;

Тав. Мэдээллийн ажилтанд эрх олгох, цахим програмд хяналт тавих

5.1 Мэдээллийн ажилтанд интернэтийн орчинд ажиллах програмд нэвтрэх эрхийг Гүйцэтгэх захирлын зөвшөөрлийг үндэслэн аюулгүй байдлын ажилтан олгоно.

5.2 Мэдээллийн ажилтан нь олгогдсон эрх хэмжээний хүрээнд цахим програм дээр ажиллаж байгаа эсэхэд сард нэгээс доошгүй удаа албаны захирал хяналт тавьж, тайланг Гүйцэтгэх захиралд танилцуулна.

5.3 Интернэт үйлчилгээний аюулгүй байдлын комисс нь шаардлагатай гэж үзвэл аюулгүй байдал хариуцсан ажилтны үйл ажиллагаанд хөндлөнгийн программ хангамжийн байгууллагаар шалгалт хийлгэж болох ба тайланг ЗЗХ-аар танилцуулна.

Зургаа. Интернэт үйлчилгээнд тавигдах шаардлага

6.1 Харилцагч нэвтрэх нэр, нууц үгээ үнэн зөв оруулснаар интернет үйлчилгээний цахим програмд нэвтрэх эрхтэй болно. Харилцагч нь интернэт үйлчилгээнд нэвтрэх бүрдээ зааврыг мөрдөж ажиллана.

6.2 Харилцагч нь интернэт үйлчилгээнд нэвтрэхдээ www.mcsd.mn интернет хаяг дээрх цахим программын тусламжтайгаар нэвтрэнэ.

6.3 Харилцагч нууц дугаар, нууц үгийг 3 удаа буруу оруулсан тохиолдолд интернет үйлчилгээний эрх түр хаагдах болно. Энэ тохиолдолд мэдээллийн ажилтан дээр өөрийн биеэр ирж интернет үйлчилгээний эрхээ сэргээлгэх буюу нууц дугаар, нууц үгийг шинээр авна.

Долоо. Интернет үйлчилгээний хөлс

7.1 Компани нь харилцагчтай байгуулсан интернет үйлчилгээний гэрээнд заасны дагуу жилд нэг удаа журмын 1 дүгээр хавсралтын дагуу бүртгэлийн хураамж авна.

Найм. Компанийн эрх, үүрэг

8.1 Компани нь дараахь үүрэг хүлээнэ. Үүнд:

8.1.1 Интернэт үйлчилгээг гэрээнд заасан нөхцлөөр түргэн шуурхай гүйцэтгэх;

8.1.2 Харилцагчийн харилцах данс болон гүйлгээний талаарх мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй байх, нууцлалыг хадгалах;

8.1.3 Журмын 4-д орсон өөрчлөлтийн талаар харилцагчдад мэдэгдэх;

8.1.4 Компани шаардлагатай гэж үзсэн тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулах эрхтэй бөгөөд энэхүү өөрчлөлтөө харилцагчдад мэдэгдэх;

8.1.3 Байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйлс, сүлжээ, техникийн гэмтэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр интернэт дансны үйлчилгээг 24 цагаас дээш хугацаагаар үзүүлэх боломжгүй болсон тохиолдолд олон нийтэд энэ тухай мэдэгдэж, яаралтай холбогдох арга хэмжээг авах;

8.2 Компани нь дараахь эрх эдэлнэ. Үүнд:

8.2.1 Журмын 4-д шаардлагатай гэж үзсэн тохиолдолд нэмэлт өөрчлөлт оруулах;

8.2.2 Шаардлагатай тохиолдолд интернэт дансны үйлчилгээний эрхийг түр хаах;

8.2.3 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг харилцагчаас шаардах;

Ес. Харилцагчийн эрх, үүрэг

9.1 Харилцагч нь дараахь үүрэг хүлээнэ. Үүнд:

9.1.1 Цахим програмыг ашиглан интернэт үйлчилгээ авахдаа журмын 1 дүгээр хавсралт маягтыг үнэн зөв бөглөж өгөх;

9.1.2 Харилцагч нь интернэт үйлчилгээний журам, зааврыг баримтлан ажиллах;

9.1.3 Харилцагчийн нууц дугаар, электрон код, нэвтрэх түлхүүр үгийг бусдад дамжуулахгүй байх, нууцлалыг хадгалах;

9.1.4 Хэрэв харилцагч өөрөө нууц мэдээлэл алдагдсан гэж үзсэн тохиолдолд утсаар мэдэгдэж орох эрхийг түр хугацаанд хаалгах ба компани дээр өөрийн биеэр ирж нууц дугаар, нууц үгийг шинээр авна.

9.1.5 Харилцагч нь системд нэвтрэх түлхүүр үгийг солих эрхтэй бөгөөд түүнийг системд нэвтэрсэн эхний өдөр заавал солих үүрэг хүлээнэ.

9.2 Харилцагч нь дараахь эрх эдэлнэ. Үүнд:

9.2.1 интернэт үйлчилгээтэй холбоотой санал, хүсэлтийг тавих;

9.2.2 өөрийн хүсэлтээр интернэт үйлчилгээний эрхийг түр хаалгах, гэрээг цуцлах;

9.2.3 гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг компаниас шаардах;

9.2.4 Хэрэв шаардлагатай гэж үзвэл интернэт үйлчилгээгээр дамжуулан авсан мэдээллийг компанид хандаж шалгуулах;

Арав. Хариуцлага

10.1 Энэ журмаар заасан шаардлагатай мэдээллийг зохих маягтын дагуу, үнэн зөвөөр, бүрэн гаргаж өгөөгүй, өөрийн зүгээс нууц кодоо нууцлаж чадаагүйгээс өөрт болон бусдад учирсан хохиролоо харилцагч өөрөө хариуцна.

10.2 Компанийн веб сайт болон энэ журмын дагуу үзүүлж буй үйлчилгээг ашиглан бусдын мэдээлэлд халдах, компанийн мэдээллийн баазад нэвтрэх, ашигласан иргэн хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Улаанбаатар хот
2016 он

“ҮЦТХТ” ХХК-ийн интернэт дансны үйлчилгээ үзүүлэх журам”-ын
хавсралт 1

Интернэт дансны үйлчилгээний хураамж

Төвлөрсөн хадгаламж дахь дансны үлдэгдэл	2 000 ₮
Төвлөрсөн хадгаламж дахь дансны дэлгэрэнгүй хуулга	4 000 ₮
Төвлөрсөн хадгаламж дахь дансанд үнэт цаасны шинжилгээ хийх	2 000 ₮
Үнэт цаасны арилжааны ханш харах	Төлбөргүй

“Интернет дансны үйлчилгээ үзүүлэх журам”-ын **Маягт 1**

Интернет үйлчилгээгээр үйлчлүүлэх
харилцагчийн хүсэлт

Энэхүү хүснэгтийг бөглөхөд анхаарах зүйлс:

1. Та энэ хүснэгтийг үнэн зөв, бүрэн гүйцэд, гаргацтай бөглөнө үү.
2. Хүснэгтийг бөглөхийн өмнө интернет үйлчилгээний гэрээний нөхцөлтэй танилцана уу.

1. Харилцагчийн мэдээлэл

Овог, нэр		Иргэний харьяалал	
Иргэний үнэмлэх		Э-шуудан хаяг	
Регистрийн №		Үүрэн телефон утасны дугаар	
Хаяг	Ажил	Утас	Ажил
	Гэр		Гэр

2. Үйлчилгээний төрөл сонгох /+/

Үйлчилгээний төрөл	Жилийн үйлчилгээний хөлс	Сонгох
Төвлөрсөн хадгаламж дахь дансны үлдэгдэл	2 000 ₮	
Төвлөрсөн хадгаламж дахь дансны дэлгэрэнгүй хуулга	4 000 ₮	
Төвлөрсөн хадгаламж дахь дансанд үнэт цаасны шинжилгээ хийх	2 000 ₮	
Үнэт цаасны арилжааны ханш харах	Төлбөргүй	

Дансны тухай мэдээлэл

1. Данс №

--	--	--	--	--	--	--	--	--	--	--

|

Би ҮЦГХТөвийн Интернет үйлчилгээний нөхцөлтэй танилцан үйлчлүүлэхийг хүлээн зөвшөөрч байна.

Хүсэлт гаргасан:

/...../

Гэрээний №

--	--	--	--	--	--	--	--	--	--	--

|

Интернет үйлчилгээний эрх олгосон:

ХӨЭБКА-ны ажилтан

/...../

ХӨЭБКА-ны захирал

/...../

Хүсэлт гаргасан огноо:

20... оны ... -р сарын ... -ний
өдөр

“Интернэт дансны үйлчилгээ үзүүлэх журам”-ын Гэрээ 1

Интернэт үйлчилгээний гэрээ №

1.Зорилго

1.1 “ҮЦТХТ” ХХК-ийн интернэт үйлчилгээгээр үйлчлүүлэх үүнтэй холбогдон төвлөрсөн хадгаламж болон интернэт үйлчлүүлэгчийн (цаашид “харилцагч” гэх, хамтад нь “талууд” гэх) хооронд үүсэх харилцааг зохицуулна.

2.Үйлчилгээний нөхцөл

2.1 Интернэт үйлчилгээ нь “ҮЦТХТ” ХХК-ийн төвлөрсөн хадгаламжинд данстай харилцагчдад интернэтээр дамжуулан өөрийн данстай холбоотой мэдээлэл авах, санал хүсэлтээ илгээх боломжийг олгоно.

2.2 Харилцагч /итгэмжлэгдсэн төлөөлөгч бол уг итгэмжлэгч/ нь дараахь үйлчилгээг сонгон интернэт үйлчилгээ авна.

Үйлчилгээний төрөл	Жилийн хураамж	Сонгох
Төвлөрсөн хадгаламж дахь дансны үлдэгдэл	2 000 ₮	
Төвлөрсөн хадгаламж дахь дансны дэлгэрэнгүй хуулга	4 000 ₮	
Төвлөрсөн хадгаламж дахь дансанд үнэт цаасны шинжилгээ хийх	2 000 ₮	
Үнэт цаасны арилжааны ханш харах	Төлбөргүй	

2.3 “ҮЦТХТ” ХХК-ийн интернэт дэх www.mcsd.mn вэб хуудсаар холбогдон интернэт үйлчилгээг авна.

2.4 Интернэт үйлчилгээний хэрэглэгчийн жилийн хураамж нь төгрөг байна.

2.5 Энэхүү гэрээг 1 жилээр байгуулах бөгөөд гэрээний хугацаа дууссан тохиолдолд аль нэг тал тухайн харилцагч гэрээ сунгах хүсэлтээ өгч төвлөрсөн хадгаламж дахь дансандаа төлбөрөө тушаасан байна.

2.6 Гэрээ талуудын хүсэлтээр дуусгавар болно.

3. Компанийн эрх, үүрэг

3.1 Компани нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

3.1.1 Интернэт үйлчилгээг гэрээнд заасан нөхцлөөр түргэн шуурхай гүйцэтгэх;

3.1.2 Харилцагчийн харилцах данс болон гүйлгээний талаарх мэдээллийг хуульд зааснаас бусад тохиолдолд гуравдагч этгээдэд задруулахгүй байх, нууцлалыг хадгалах;

3.1.3 Журмын 4-д орсон өөрчлөлтийн талаар харилцагчдад мэдэгдэх;

3.1.4 Компани шаардлагатай гэж үзсэн тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулах эрхтэй бөгөөд энэхүү өөрчлөлтөө харилцагчдад мэдэгдэх;

3.1.5 Байгалийн гамшиг, давагдашгүй хүчин зүйлс, сүлжээ, техникийн гэмтэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр интернэт дансны үйлчилгээг 24 цагаас дээш

хугацаагаар үзүүлэх боломжгүй болсон тохиолдолд олон нийтэд энэ тухай мэдэгдэж, яаралтай холбогдох арга хэмжээг авах;

3.2 Компани нь дараахь эрх эдэлнэ. Үүнд:

- 3.2.1 Журмын 4-д шаардлагатай гэж үзсэн тохиолдолд нэмэлт өөрчлөлт оруулах;
- 3.2.2 Шаардлагатай тохиолдолд интернэт дансны үйлчилгээний эрхийг түр хаах;
- 3.2.3 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг харилцагчаас шаардах;

4. Харилцагчийн эрх, үүрэг

4.1 Харилцагч нь дараахь үүрэг хүлээнэ. Үүнд:

- 4.1.1 Цахим програмыг ашиглан интернет үйлчилгээ авахдаа журмын 2 дугаар хавсралт маягтыг үнэн зөв бөглөж өгөх;
- 4.1.2 Харилцагч нь интернэт үйлчилгээний журам, зааврыг баримтлан ажиллах;
- 4.1.3 Үйлчилгээнд нэвтрэх нууц дугаар, электрон код, нэвтрэх түлхүүр үгийг бусдад дамжуулахгүй байх, нууцлалыг хадгалах;
- 4.1.4 Хэрэв харилцагч өөрөө нууц мэдээлэл алдагдсан гэж үзсэн тохиолдолд компани дээр өөрийн биеэр ирж нууц дугаар, нууц үгийг шинээр авна.
- 4.1.5 Харилцагч нь системд нэвтрэх түлхүүр үгийг солих эрхтэй бөгөөд түүнийг системд нэвтэрсэн эхний өдөр заавал солих үүрэг хүлээнэ.

4.2 Харилцагч нь дараахь эрх эдэлнэ. Үүнд:

- 4.2.1 Интернэт үйлчилгээтэй холбоотой санал, хүсэлтийг тавих;
- 4.2.2 Өөрийн хүсэлтээр интернэт үйлчилгээний эрхийг түр хаалгах, гэрээг цуцлах;
- 4.2.3 Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг компаниас шаардах;
- 4.2.4 Хэрэв шаардлагатай гэж үзвэл интернэт үйлчилгээгээр дамжуулан авсан мэдээллийг компанид хандаж шалгуулах;

Тав. Хариуцлага

5.1 Шаардлага хангахгүй техник, програм хангамж ашиглаж, нууцлал, аюулгүй байдлыг бүрэн хангаагүйгээс харилцагчийн дансны гүйлгээний мэдээлэл бусдад алдагдсанаас харилцагчид хохирол учирсан тохиолдолд хариуцлагыг компани бүрэн хүлээнэ.

5.2 Интернэтээр үйлчлүүлэхэд ашиглагдах нууц үгээ харилцагч өөрийн болгоомжгүй байдлаар бусдад алдсанаас учирсан хохирлыг компани хариуцахгүй.

Гэрээ байгуулсан

“ҮЦТХТ” ХХК-ийг төлөөлж:

Харилцагч:

ХӨЭБКА-ны ажилтан / /

ХӨЭБКА-ны захирал /

20. . . . оны . . . сарын . . . –ны өдөр